



# ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

## айгаа Хэрэг бүрдүүлэх явцад урьдчилан хоригдож буй хүнд олгох

Та Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч шүүгчээр шүүгдэн урьдчилан хоригдож байгаа болно. Уг баримт нь таны эдлэх гол эрх ба танд өгөгдөх гол мэдээллүүдийн талаар таньд сануулна.

**Та уг баримтыг урьдчилан хоригдож байгаа хугацаанд өөртөө хадгална.**

### Гэмт үйлдлийн танилцуулга

Та өөрийн үйлдсэн ба үүний улмаас урьдчилан хоригдон шалгагдаж байгаа зөрчлийн зүйлчлэл, огноо ба үйлдсэн газар болон урьдчилан хоригдож байгаа шалтгааныг мэдэх эрхтэй.

### Өмгөөлөгчийн туслалцаа

Та байцаагдах хугацаандаа өөрийн сонголтоор эсвэл с улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгчийн туслалцааг авахаар хүсэлт гаргах эрхтэй.

Та өөрийн өмгөөлөгчтэйгөө бичгээр чөлөөтэй харилцаж болох ба тэр таны байцаалтанд дуудагдаж оролцоно.

*Хэрэв та насанд хүрээгүй хүн буюу таны гэр бүл танд өмгөөлөгч аваагүй тохиолдолд улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгч танд томилж өгнө.*

### Үг хэлэхгүй байх эрх

Байцаалтын явцад та, мэдүүлгээ өгч, таниас асуусан асуултад хариулах эсвэл үг хэлэхгүй чимээгүй байх эрхтэй.

### Хэлмэрчийн туслалцаа

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

### Суллагдах хүсэлт гаргах эрх

Та ямар ч үед хяналтын прокурорт таныг суллах талаар хүсэлт гаргах эрхтэй. Уг хүсэлтийг хяналтын прокурор болон Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч авч хэлэлцэж шалгах болно.

### Эрх чөлөө хасах хугацаа

Урьдчилан хоригдож байгаа хугацаа нь таныг насанд хүрсэн эсэхээс хамаардаг ба таны үйлдсэн гэмт хэрэг эсвэл зөрчил хүнд хөнгөн эсэхээс, мөн та урьд нь шүүхээр яллагдан хоригдож байсан эсэхээс хамаарна.

Тус хугацаа нь таныг хорьсон шүүгчийн шийдвэр дээр заагдсан байдаг.

Зарим тохиолдлуудад, таны хоригдох хугацаа сунгагдаж болно. Энэ хугацаа сунгалт нь заавал таны ба таны өмгөөлөгчийн байлцсан шүүхийн хэлэлцүүлгээр шийдэгдэнэ.

### **Зарим хүний талаархи мэдээлэл**

Та өөрийн дурын болон ялангуяа өөрийн гэр бүлийн гишүүдэд урьдчилан хоригдож байгаа тухай мэдэгдэх эрхтэй.

Хэрэв та гадаад улсын иргэн бол өөрийн улсын консулын газарт мэдэгдэх эрхтэй.

### **Эмчийн үзлэг**

Та эмчийн үзлэгээр орох хүсэлт гаргаж болно.

### **Таны хавтаст хэргийг үзэх**

Та өөрийн өмгөөлөгчөөр дамжуулан хавтаст хэргийн нэг хуулбарыг өөртөө авч үлдэх эрхтэй. Хяналтын прокурор нь, мөрдөн шалгагдаж буй хүн хохирогсдод дарамт үзүүлэх, тэдний өмгөөлөгчдөд, гэрч, мөрдөн байцаагчид шинжээч нар ба уг хэргийг мэдэх хүн бүрт дарамт үзүүлж болзошгүйн улмаас хавтаст хэргийн зарим хэсгүүдийг таны гарт олгохоос татгалзаж болно.